

МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Удиртгал

УИХ-аас 2015 онд баталж, 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар тооцоолсон болно.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг тандан судлах явцад тус тус гүйцэтгэнэ. Энэ нь тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсгэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөр иргэнд зардал үүсгэхгүй, харин хуулийн этгээд, төрийн байгууллагад шинэ чиг үүрэг нэмэх, шинээр үүрэг хүлээлгэх зохицуулалтууд тусгасан. Хуулийн төслөөр салбарын төрийн захиргааны төв байгууллага буюу тухайн салбарын сайдад зөвлөх чиг үүрэг бүхий сайдын Зөвлөлөөр мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх эсэхийг болон тухайн мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд аккредитаци хийх чиг үүргийг нэмж байгаа тул төрд үүсэх зардлын тооцоог төрийн захиргааны төв байгууллагад үүсэх зардлаар тооцож гаргасан.

Түүнчлэн хуулийн этгээдийн чиг үүргийг тодорхойлж заасан тул үүнтэй холбоотой үүсэх заардлын тооцоог тооцов.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Нэг. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг батлан хэрэгжүүлснээр төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг батлан хэрэгжүүлснээр төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн

дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараахь үе шаттайгаар гаргалаа. Үүнд:

- Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
- Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийг хэрэгцээг тогтоох;
- Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
- Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягтлах.

Нэгдүгээр үе шатанд:

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон.

Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамаарууллаа. Үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт ажлын байрны зураг авалтын үр дүнд гаргасан хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулах авч үзэв. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ 96000 минут ажиллана гэсэн үг.

1.1. Төрийн захиргааны төв байгууллагад үүсэх зардал тооцсон байдал

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд салбарын төрийн захиргааны төв байгууллага дараахь шинэ чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулахыг хүсэгч нь хуульд заасан баримт бичгийг бүрдүүлж, салбарын төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.
- Салбарын төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 8.1-д заасан хүсэлтийг хүлээн авч, сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.
- Мэргэжлийн холбоог байгуулагдсанаас нь хойш 5 жил тутамд үйл ажиллагаагаа салбарын төрийн захиргааны төв байгууллага магадлан итгэмжилнэ.

Хоёрдугаар шатны хүрээнд: Үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Монгол Улсын Засгийн газар нь хуулийн төслийн 7.6, 18.7, 19.4-т тусгагдсан үйл ажиллагааг зохион байгуулах давтамж тогтмол биш эсхүл жилдээ 1 гүйцэтгэх тул аргачлалын дагуу давтамжийг 1 гэж тооцлоо.

д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа минут	х	Давтамж	Нийт хугацаа
1	Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулахыг хүсэгч нь хуульд заасан баримт бичгийг бүрдүүлж, салбарын төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.	Хүсэлт хүлээн авах	10		1	10
		Бичиг баримтын бүрдэл шалгах	480		1	480
		Шаардлагатай тохиолдолд хүлээн авахаас татгалзах	10		1	10
	НИЙТ					490
Шаардлагатай хүний нөөц = 500/ 60 минут = 8.2 цаг/ 8 = 1.1025 өдөр /0,005хүн						

д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа минут	х	Давтамж	Нийт хугацаа
2	Салбарын төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 8.1-д заасан хүсэлтийг хүлээн авч, сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.	Хурлын бэлтгэл хангах	120		1	120
		Хурал зохион байгуулах	180		1	180
		Хурлаар хүсэлтийг хэлэлцүүлнэ.	240		1	240
		Холбогдох шийдвэр гаргаж, мэдэгдэх	10		1	10
	НИЙТ					550
Шаардлагатай хүний нөөц = 550/ 60 минут = 9.1 цаг/ 8 = 1.13 өдөр /0,006хүн						

д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа минут	х	Давтамж	Нийт хугацаа
3	Мэргэжлийн холбоог	Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах	10		1/5	2

байгуулагдсанаас нь хойш 5 жил тутамд үйл ажиллагаагаа салбарын төрийн захиргааны төв байгууллага магадлан итгэмжилнэ.	Холбогдох журмын дагуу магадлан итгэмжлэх	1440		1/5	288
	Холбогдох шийдвэр гаргаж, мэдэгдэх	10		1	10
НИЙТ					300
Шаардлагатай хүний нөөц = 300/ 60 минут = 5 цаг/ 8 = 0.6 өдөр /0,003 хүн					

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Төрийн захиргааны төв байгууллага	1340	96000	0.013

Дээрх тооцооллыг харахад төрийн захиргааны төв байгууллагад 1340 минут буюу 22.3 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 0,013 хүн шаардлагатай байна. Иймд хуулийн төсөлд шинээр тусгасан дээрх 3 чиг үүргийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагад хүний нөөцийн ачаалал шинээр үүсэхээргүй байна.

3. Аж ахуйн нэгжид үүсэх зардал

Хуулийн төсөлд мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааг явуулахын өмнө салбарынхаа төрийн бус байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээх бүртгэлийн байгууллагад хандаж бүртгүүлэх талаар тусгажээ. Энэ үүргийг хэрэгжүүлэхийн тулд хуулиар шаардсан бичиг баримтыг бүрдүүлж, салбарын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх шаардлага бий болж байна.

Дээрх үүргийг хэрэгжүүлэхийн тул аж ахуйн нэгжид бий болох хүний нөөцийн зардлыг дараахь байдлаар гаргалаа.

Одоогийн байдлаар уг хуулийн төсөлд тусгасан шаардлагыг хангахуйц мэргэжлийн нэгдсэн холбоо байхгүй тул тохиолдлын тоог 1 гэж авч үзсэн болно.

Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Хугацаа /мин	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ/мин/
---------	------------------------	----------------	--------------	---------	-----------------------------

Салбарын төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авах	Хобогдох хууль, журамтай танилцах	1	30	1	30
	Үүсгэн байгуулах шийдвэр боловсруулах	1	30	1	30
	Үүсгэн байгуулах хурал зохион байгуулах	1	30	1	30
	Хуралдуулах	1	120	1	120
	Дүрэм боловсруулах	1	120	1	120
	Гишүүдийг мэдээллийг авч, нэгтгэх	1	60	1	60
	Баримт бичгийг нягтлах	1	30	1	30
	Яаманд хүсэлт гаргах	1	30	1	30
					450

Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Хугацаа /мин	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ/мин/
Улсын бүртгэлд бүртгүүлэх	Хобогдох хууль, журамтай танилцах	1	30	1	30
	Бичиг баримтаа бүрдүүлэх	1	30	1	30
	Өргөдөл бөглөх	1	90	1	90
	Нэрийн лавлагаа авах	1	30	1	30
	Тэмдэгтийн хураамж төлөх	1	10	1	10
	Хүсэлтээ хүргүүлэх	1	30	1	30
	Гэрчилгээ авах	1	10	1	10
					230

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
------	------------------------	-------------------------------	---------------------------------

Мэргэжлийн нэгдсэн холбоо	680 мин	96000	0,007
---------------------------	----------------	--------------	--------------

Хуулийн этгээдийг Улсын бүртгэлд шинээр бүртгүүлж гэрчилгээ авахад Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтад заасны дагуу 44000 төгрөгний тэмдэгтийн хураамж төлөх, болон бүрдүүлсэн материалаа хүргэх, гэрчилгээ авах зэрэг нэмэлт зардал гарна.

Тэмдэгтийн хурааж: $44000 \times 1 = 44000$ төгрөг

Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт очих болон гэрчилгээ авахад ажилтан 2 удаа явах бөгөөд унааны зардлыг 5000 төгрөгөөр тооцлоо.

$5000 \times 1 = 5000 \times 1 = 5000$ төгрөг

Нийт нэмэлт зардал: $44000 + 5000 = 49000$

Гуравдугаар үе шатны хүрээнд: Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлын мэдээллийн үндсэн дээр гаргадаг бөгөөд ажиллах шаардлагатай хүний нөөцтэй тэдгээр зардлын оногдох хэсгүүдийн нийлбэрээр уг зардлыг тооцно.

Дээр гаргасан хүний нөөцийн хэрэгцээ шаардлага бий болсон тохиолдолд түүн дээр үндэслэн тухайлсан байгууллагын хувьд зардлыг тооцон гаргах боломжтой байсан. Манай тохиолдлын хувьд хүний хэрэгцээ гараагүй тул цалин болон бусад материаллаг зардлыг тооцох шаардлагагүй болно.

Дөрөвдүгээр үе шатны хүрээнд: Хувилбарыг нягтлан хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл төсвийн зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтооно.

Хуулийн төсөлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага болон мэргэжлийн нэгдсэн холбоонд нэмэлт зардал үүсэхгүй гэж тооцоолов.